

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

/2024 оны жилийн эцсийн байдлаар /

2024.12.19

Дархан-Уул

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийг хяналтанд авсан зүйл, заалттай харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, үүрэг болгосон зүйл, заалтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд үнэлгээний зорилго оршино.

Хяналтанд авсан Монгол Улсын хууль, УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим систем буюу new.unelgee.gov.mn –ийн Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн цэсэнд байршсан 152 шийдвэрийн 290 заалт, Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс нэгтгэж ирүүлсэн тайланг уншин гүйцэтгэв.

Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга нарын 2024.12.19-ны өдрийн хурлын гишүүдээс өгсөн санал, Төрийн захиргаа удирдлагын хэлтэс, Хууль эрх зүйн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хонгор сумын ЗДТГ-аас ирүүлсэн нэмэлт мэдээлэл, Засгийн газрын гишүүнтэй 2024 онд байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийн статистик тоо баримтад үндэслэн сайжруулалтыг гүйцэтгэлээ.

Хяналтанд авсан шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэхдээ “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар бүлгийн 6.3 дахь заалтын дагуу 5 шатлалт арга зүйгээр, шийдвэрийн зүйл, заалтын гүйцэтгэлийн үр дүнг хүрэх түвшин буюу тавьсан зорилтод харьцуулан хувиар тооцож гаргалаа.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, үр дүн

2024 оны жилийн эцсийн байдлаар аймгийн Засаг дарга хяналтанд авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон:

- ✓ Монгол Улсын 8 хуулийн 23 заалт,
- ✓ УИХ-ын 12 тогтоолын 49 заалт,
- ✓ УИХ-ын байнгын хорооны 18 тогтоолын 44 заалт,
- ✓ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 5 зарлигийн 11 заалт,
- ✓ ҮАБЗ-ийн 6 зөвлөмжийн 10 заалт,
- ✓ Засгийн газрын 55 тогтоолын 80 заалт,
- ✓ Засгийн газрын хуралдааны 47 тэмдэглэлийн 72 заалт,
- ✓ Засгийн газрын 1 албан даалгаврын 1 заалт,

нийт 152 шийдвэрийн 290 заалтыг хяналтанд авч, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн цахим сан “ХТТШ” цэсэд тайлант хугацаанд 17 удаа байршсан давхардсан тоогоор 1870 заалтын хэрэгжилтэд, ХШҮ хийж, цахим санд хугацаанд нь байршуулж, баталгаажууллаа.

Хүснэгт 1-с дэлгэрэнгүйг харна уу.

№	Заалтын тоо	Баталгаажуулсан хугацаа/ баталгаажуулах хугацаа		Үнэлгээ /%/
1	Яаралтай 3	I/08	I/08	90.0
2	Яаралтай 32	I/31	I/31	93.57
3	128	II/05	II/08	90.99
4	101	III/10	III/10	66.63
5	117	IV/10	IV/10	76.42
6	Яаралтай 2	IV/08	IV/08	100
7	122	V/10	V/10	88.41
8	241 давхардал	VI/13	VII/01	-
9	10 Шинэ хоршоо	V/31	V/30	90%
10	Яаралтай Шинэ хоршоо-10	VII/08	VII/08	84.60
11	119	VII/09	VI/10	89.43
12	125	VIII/09	VIII/10	91.53
13	135	IX/10	IX/10	90.55
14	144	X/09	X/10	89.31
15	145	XI/10	XI/10	88.25
16	146	XII/10	XII/10	92.43
17	Яаралтай 290	XII/10	XII/20	94.17
	1870			

Үүнээс: Хяналт хэрэгжүүлэх газраас өгсөн үүрэг чиглэлийн дагуу тайлант хугацаанд яаралтай горимоор 5 удаагийн нийт 337 заалтын хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийн, цахим системд хугацаанд байршуулан баталгаажууллаа.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр 2024 оны жилийн эцсийн байдлаар **94.17%** хувийн хэрэгжилттэй **4.70** онооны үнэлгээтэй байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад (2022 онд 89.60%, 2023 онд 90.99%) 3.18%-иар өссөн байна.

Үнэлгээг хураангуй байдлаар харуулбал:

№	Үнэлгээ	Нийт	
1.	Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо	152	
2.	Хяналтанд авсан нийт зүйл, заалтын тоо	290	
3.	Үүнээс	Бүрэн хэрэгжсэн 100% (90-100%)	225
		Хэрэгжих шатанд 70% (50-89%)	41
		Хэрэгжилт хангалтгүй 30% (10-49%)	5
		Хэрэгжээгүй 0% (0-9%)	-
	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	19	
	Хэрэгжилтийн ерөнхий дүн, хувь	94.17% буюу 4.70 оноо	

Холбогдох шийдвэрийн төрөл тус бүрээр харуулбал:

№	Үнэлгээ	Нийт	Шийдвэр, төрөл								
			Монгол Улсын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	ҮАБ-ын зөвлөлийн зөвлөмж	
1.	Хяналтанд авсан шийдвэрийн тоо	152	8	12	18	5	55	47	1	6	
2.	Хяналтанд авсан нийт заалтын тоо	290	23	49	44	11	80	72	1	10	
3.	Үүнээс	Бүрэн хэрэгжсэн 100% (90-100%)	225	20	29	39	11	61	56	-	9
		Хэрэгжих шатанд 70% (50-89%)	41	2	11	4	-	14	9	-	1
		Хэрэгжилт хангалтгүй 30% (10-49%)	5	-	1	-	-	2	2	-	-
		Хэрэгжээгүй 0% (0-9%)	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	19	1	8	1	-	3	5	1	-	
Хэрэгжилтийн ерөнхий хувь		94.17%	97.27%	90.24%	97.21%	100%	92.73%	93.88%	-	97.0%	

2024 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан Монгол Улсын хуулийн 23 заалтыг хяналтад авч хэрэгжилтийг 97.27% -иар ханган ажилласан бол УИХ-ын тогтоолын 49 заалт 90.24%, УИХ-ын байнгын хорооны тогтоол 97.21%, Засгийн газрын тогтоол 92.73%-ийн хэрэгжилттэй байна.

2017-2024 онуудад хяналтад авсан шийдвэрийн төрлийг харьцуулж харуулбал:

(тухайн жилийн эцсийн байдлаар)

Он	Заалт, тоо	Нийт шийдвэрийн төрөл, үүнээс									
		МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	Засгийн газрын тогтоол	Ерөнхий Сайдын захирамж	Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	ЗГХЭГ-ын даргын тушаал
2017	107	0	0	3	4	3	58	0	27	12	0
2018	149	2	3	3	7	3	74	5	24	13	15
2019	99	1	1	3	2	0	60	4	16	8	4
2020	182	23	1	4	4	8	95	1	23	24	0

2021	152	27	2	4	10	15	67	1	26	0	0
2022	124	68	-	4	14	8	13	-	17	-	-
2023	200	31	10	44	11	8	42	-	50	4	-
2024	290	23	49	44	11	10	80	-	72	1	-

Дээрх хүснэгтээс харахад тухайн жилд хяналтад авсан нийт заалтын:

- 2017 онд 58 буюу 54.20%
- 2018 онд 74 буюу 49.66%
- 2019 онд 60 буюу 60.60%
- 2020 онд 95 буюу 52.19%
- 2021 онд 67 буюу 44.07%
- 2022 онд 17 буюу 13.70%
- 2023 онд 42 буюу 21.0%
- 2024 онд 80 буюу 27.5%-ийг Засгийн газрын тогтоолын заалт эзэлж байна.

2024 онд хяналтад авсан 290 заалтын 152 буюу 52.3%-ийг Засгийн газрын тогтоол болон Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн буюу **асуудлыг хамтран хэлэлцэж шийдвэрлэх үндсэн дээр баталсан баримт бичгийн заалтууд** байлаа.

30%-иар үнэлэгдсэн 5 заалтын хувьд 2024 онд батлагдан, хэрэгжүүлэхээр үүрэг болгосон 5 шийдвэрийн заалтууд байх бөгөөд удирдлага, зохион байгуулалт, санхүүжилтийг шийдвэрлэвэл хэрэгжих боломжтой байна.

Эдгээр 5 заалтын хэрэгжилтийг танилцуулбал:

№	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Үнэлгээ
19	70	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-05-02 Дугаар 2024_37	3.в. в/аймаг, дүүрэг бүрд байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд зориулсан нөхөн сэргээх, нийгэмшүүлэх, боловсрол олгох, өдөр өнжүүлэх хөгжлийн төв болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төрөлжсөн асармж халамжийн төв байгуулах, холбогдох санхүүжилт, хүний нөөцийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх.	ЕБС-д төрөлжсөн асармж халамжийн төв байхгүй бөгөөд бүх сургуулиуд ердийн сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа. СӨББ-ийн хувьд 7-р цэцэрлэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сургалт явуулж байна.	30%
97	205	Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2024-08-07 Дугаар 2024_28	3.4. "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд хэрэгжүүлэх төслийг орон нутгийн хөгжлийн болон бэлчээр ашиглалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан мал аж ахуйн салбарын үндсэн хөрөнгө, бүтээн байгуулалтын чиглэлд хандуулах;	"Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд сумдад зээлийн дэмжлэг авсан малчдад газар олгохоор 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар саналаа хүргүүлсэн.	30%
100	213	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай	4. Теле камераар цуглуулсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд ашиглахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, эрсдлээс хамгаалах	Теле камерын хяналтын дэд төв"-ийн 11 заалт бүхий журам боловсруулан алба хаагчид	30%

		2024-09-18 Дугаар 2024_86-1	шаардлагатай арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй.	томилогдсоны дараа мөрдүүлэхээр ажиллаж байна.	
134	265	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэл 2024-01-31 Дугаар 2024_5	12.9.2. Орон нутагт мал, мах худалдаалах зориулалтын цэг байгуулах арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Холбогдох байгууллагуудтай хамтран орон нутагт мах худалдан авах явуулын цэг ажиллуулах боломжийг судлаж байгаа бөгөөд шаардлага хангах явуулын тохирох цэг одоогоор алга байна.	30%
142	276	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэл 2024-05-08 Дугаар 2024_18.1	19.3.2. Уг төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд хэрэгжилтийг зохион байгуулах, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгав.	“Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэхээр төлөвлөж байна	30%

Гурав. Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн хяналтнаас хасаж, орон нутгийн хяналтад авахаар хүргүүлж буй санал:

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024.08.29-ны өдрийн “Тайлан, зөвлөмж хүргүүлэх тухай” 01/620 тоот албан бичгийн хавсралтаар ирүүлсэн “Дархан-Уул аймгийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан”-гийн “Найм.Зөвлөмж”-ийн хүрээнд хэрэгжилтийг хангуулах зорилгоор үйл ажиллагааг хэрэгжүүлсэн, хүчингүй болсон, тогтмолжсон, чиг үүрэгт хамааралгүй дараах 9 шийдвэрийн 9 заалтыг хяналтаас хасуулах саналыг тайлбарын хамт, цахим санд баталгаажууллаа.

Дэлгэрэнгүйг хүснэгтээс харна уу.

Хасах санал	Шийдвэрийн тоо	Заалтын тоо
2017 он	12	15
2018 он	25	34
2019 он	18	21
2020 он	25	26
2021 он	5	6
2022 он	6	6
2023 он	8	8
2024 он	9	9

Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ /Зөвлөмж/

Хэрэгжилт хангалтгүй буюу 30%-иар үнэлэгдсэн 5 заалт, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 19 заалт буюу 2024 оны 12 сард батлагдсан шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангуулахад бодлогын хэлтсүүд, хэрэгжүүлэгч агентлагууд “Үйл ажиллагааны төлөвлөгөө” гарган хэрэгжилтийг ханган ажиллах, мэргэжил арга зүйн зөвлөгөө, чиглэлийг өгч ажиллалаа.

ТАНИЛЦСАН:
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА П.БАЯРСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНХСҮРЭН